

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 1-р сарын 21.  
2022.01.

№ 07/2022

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас: Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Эрдэнэбаатарын Ариунболд, нөгөө талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан цехийн Худагийн эргүүл Жамсрангийн Жамбаа нар Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1 дэх заалтыг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээгээр Амгалан дулааны станц ТӨХК-ийн 4,5,7,8 дугаар цэвэр усны худагуудад эргэлт шалгалт хийхэд Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан цехийн Худагийн эргүүл Ж.Жамбаагийн хүсэлтийн харгалзан өөрийнх нь тээврийн хэрэгслэлийг ашиглуулах, түүний аюулгүй байдал, бэлэн байдал, зарцуулах түвшний асуудлыг шийдвэрлэх зорилготой.

### НЭГ. АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ЭРХ ҮҮРЭГ


- 1.1 Батлагдсан эргэлт шалгалтын маршрут өгнө.
- 1.2 Батлагдсан эргэлт шалгалтын хуваарийг өгнө
- 1.3 Тээврийн хэрэгслийн шатахууны зарцуулалтын нормыг комисс гарган тогтооно.
- 1.4 Тээврийн хэрэгслийн шатахуун нормыг хуанлийн хоногоор тооцож олгоно.
- 1.5 Тээврийн хэрэгслийн шатахуун нормыг 100 км-т 10 литр дизель түвш зарцуулахаар замын хуудсаар олгоно.
- 1.6 Тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой хууль, дүрэм, журмын зөрчил, үүнээс үүдэн гарсан аливаа хариуцлага, тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ, үүссэн хохиролыг Амгалан дулааны станц ТӨХКомпани хариуцахгүй.

### ХОЁР. АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ЗУУХАН ЦЕХИЙН ХУДАГИЙН ЭРГҮҮЛ Ж. ЖАМБААГИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Батлагдсан эргэлт шалгалтыг маршрутын дагуу гүйцэтгэнэ.
- 2.2 Эргэлт шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 2.3 Тээврийн хэрэгслийн шатахууныг 100 км-т 10 литр дизель түвш зарцуулахаар тооцон авна.
- 2.4 Шатахуун зарцуулалтыг тооцоог замын хуудсаар хийнэ.
- 2.5 Тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой хууль, дүрэм, журмын зөрчилгүй ажиллана. Зөрчилөөс үүсэн хохиролыг биечлэн хариуцна.
- 2.6 Тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, засвар, үйлчилгээ өөрөө хариуцна.
- 2.7 Тээврийн хэрэгслийн татвар, даатгалыг өөрөө хариуцна.
- 2.8 Тээврийн хэрэгсэлтэй холбоотой үүссэн хохиролыг өөрөө хариуцна.
- 2.9 Тээврийн хэрэгсэл ажилд гарах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд үзлэг шалгалтыг саадгүй гүйцэтгэх үүргийг хүлээнэ.

### ГУРАВ. ХУГАЦАА

- 3.1 Энэхүү гэрээг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.



### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нэг талаас:  
Амгалан дулааны станц ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захирал  
Ш.Баянмөнх  
СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан  
бодогчийн ажил үүргийн түр орлон  
гүйцэтгэгч                          Θ.Удвал  
Зуухан цехийн дарга                          Э.Ариунболд  
Хуулийн мэргэжилтэн                          Г.Саруул

Нөгөө талаас:  
Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан  
цехийн Хулагийн эргүүл  
Ж. Жамбаа